



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/329

Номгон

"Торгоны зам" Олон улсын автомашины ралли
уралдааныг хамтран зохион байгуулах ажлын
хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улс, Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэрийг дамнасан "Торгоны зам" олон улсын автомашины ралли уралдааныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Д.Энхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд Т.Хишигбаатар	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Б.Мөнхбаяр	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа
Ж.Алтангэрэл	Онцгой байдлын газрын дарга, Хурандаа
Н.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын дарга
Г.Ганчулуун	Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга
Б.Мөнхтогтох	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Г.Энхбаяр	Баянхонгор сумын Засаг дарга
Т.Отгонбаатар	"Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын захирал
Ц.Баясгалан	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын захирал
Ж.Уламбаяр	"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ний захирал
М.Мөнхбат	"Чандмань-Баянхонгор" ХК-ний захирал

024010791

2.

Ц.Батхүү Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч, Хурандаа
Д.Мөнхжаргал Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дарга
Д.Мөнхцэцэг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Бат-Өлзий Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга

Аймгийн автомашин, мотоциклийн холбоо (Зөвшилцсөнөөр)


Нарийн бичгийн дарга

Д.Содномсамдан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

2.Олон улсын автомашины ралли уралдааныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран өндөр түвшинд зохион байгуулж, олон нийт иргэдэд сурталчлан, холбогдох тайлан, баримт бичгийг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн архивын тасагт хүлээлгэн өгч ажиллахыг Ажлын хэсэг (Д.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/294 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН